

МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Оршил

Монгол Улсын Банкны тухай хуулийг 1991 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр батлан гаргаснаар Монгол улсад Төв банк, арилжааны банк гэсэн 2 шатлал бүхий банкны тогтолцоо бүрэлдэн тогтсон билээ. Энэ үеэс Монголбанк нь банк хоорондын клирингийн тооцоог зохион байгуулах арга хэмжээг авч 1993 оноос эхлэн банк хоорондын төлбөр тооцоог нэвтрүүлсэн.

1995 онд “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль” батлагдсанаар бэлэн бус төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, чек, вексель, төлбөрийн карт болон төлбөрийн бусад баримтаар гүйцэтгэх болсон. “Векселийн тухай хууль” батлагдан гарсан нь бэлэн бус төлбөр тооцооны хамрах хүрээг өргөжүүлж, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд чухал алхам болсон юм. Энэ үеэс эхлэн банк хоорондын гүйлгээг өдөрт 2 удаа тогтмол цагуудад хүлээн авч, хуваарилах, банк хоорондын гүйлгээний үр дүнгийн тооцоог өдрийн эцэст тогтсон цагт нийлж тохируулж байсан. Нэгдсэн цахим сүлжээнд арилжааны банкны төвүүдийг холбосон төдийгүй 1997 онд Монголбанк нь арилжааны банкуудын нягтлан бодох бүртгэлийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор банк хоорондын клирингийн тооцооны журмыг шинээр гаргаж, Монголбанк олон улсын төлбөр тооцооны СВИФТ¹ сүлжээнд холбогдсоноор гадаад төлбөр тооцоог шуурхай дамжуулж, гадаад улс орнуудтай хийх гүйлгээний найдвартай байдал хангагдах болсон билээ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн тушаалаар батлагдсан “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”, “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”-ын дагуу 2006 оны 2 дугаар сараас эхлэн банк хоорондын гүйлгээг их, бага дүнтэй ялган хоёр системийг нэгэн зэрэг ашиглах болсон.

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан “Санхүүгийн чадавхыг хөгжүүлэх төсөл”-ийн дагуу төлбөр тооцооны системийг шинэчлэх ажлын хүрээнд “Төлбөр тооцооны төв”-ийг байгуулан ажиллаж байна. Төлбөр тооцооны төв нь банкуудын төв болон Сангийн Яамны Төрийн сангийн газрыг санхүүгийн дундын сүлжээнд холбосноор 2006 оны 2 дугаар сарын 1-нээс 2009 оны 6 дугаар сарын 1-ий өдрийг хүртэл хугацаанд банкууд болон Сангийн яамнаас ирүүлж буй банк хоорондын тооцоогоор дамжин хийгдэх их, бага дүнтэй гүйлгээг холимог байдлаар багцаар нь хүлээн авч ангилан их дүнтэй гүйлгээг Монголбанкны Банк, салбар хоорондын төлбөр тооцооны алба руу, бага дүнтэй гүйлгээг хүлээн авагч банкууд болон Сангийн яам руу шууд хуваарилан дамжуулж байсан. Бага дүнтэй гүйлгээний, клирингийн үр дүнгийн тооцоог өдрийн эцэст тогтмол цагт Банк, салбар хоорондын төлбөр тооцооны алба руу дамжуулснаар тус алба нь холбогдох банкуудын харилцах данс руу хаалтын гүйлгээг хийж байв.

Мөн дээр дурдсан төслийн хүрээнд Монголбанк нь Банк хоорондын их дүнтэй гүйлгээний бодит цагийн горим буюу “Банксүлжээ” системийг 2009 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс нэвтрүүлсэн юм. Энэ нь их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог боловсруулах хугацааг багасгах, боловсруулалтын бүх шатанд төлбөрийн мэдээллийн бүрэн бүтэн ба аюулгүй байдлыг хангах, харилцах дансны үлдэгдлийн мэдээллийг бодит цагаар хүлээн авах

¹ Олон улсын банк санхүүгийн байгууллагын хооронд санхүүгийн мэдээг дамжуулдаг цахим сүлжээ.

боломжийг оролцогчдод (банкууд болон Сангийн яамны Төрийн сангийн газар) олгосноор банкуудын эх үүсвэрийн үр ашгийг нэмэгдүүлэх, төлбөрийн үл буцаагдах байдлыг хангах ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Тус системээр үнэт цаасны болон валютын арилжааны төлбөр тооцоо хийгдэх боломж бүрдэж, Монгол Улсын төлбөр тооцооны систем хөгжлийн шинэ шатанд гарсан болно.

Одоогийн байдлаар Монгол Улсын банк хоорондын төлбөр тооцоо нь дараахь хоёр системээр хийгдэж байна. Үүнд:

1. Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын харьяанд ажиллаж буй их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны “Банксүлжээ” систем.
2. Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын Төлбөр тооцооны төвийн ажиллуулж буй “Санхүү дундын сүлжээ” систем.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 19 тоот тушаалаар Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дүнгийн хязгаарыг 1 000 000 (нэг сая) төгрөгөөр тогтоосон болно.

Монгол улсад бүрэн хэмжээний төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлж байгаа санхүүгийн байгууллагуудын төлбөр тооцоо хийх үйл ажиллагааг хууль, тогтоомжийн талаас нь зохицуулалт хийх Монгол улсын хэмжээнд мөрдөх хуулийн бүтэц, тогтолцоо, эрх зүйн акт хараахан бүрдээгүй байна. Гэхдээ Төв банкны зүгээс сүүлийн жилүүдэд төлбөр, тооцооны механизмыг улам боловсронгуй болгох, зах зээлд оролцогчдын үйл ажиллагааны үр дүнг улам дээшлүүлэх, төлбөрийн системийн эрсдлийг багасгах арга хэмжээг тухай бүр авч ажиллаж ирсний зэрэгцээ 2011 ондоо багтаан “Төлбөр тооцооны системийн тухай хууль”, системийн хяналтын гарын авлагыг холбогдох байгууллагуудаар батлуулж, мөрдүүлж ажиллахаар бэлтгэж байна.

1. Ерөнхий бүтэц

1.1. Хуулийн ерөнхий бүтэц, тогтолцоо

Монгол Улсын төлбөр тооцооны системийн шууд оролцогч нь нэгдүгээрт: Монгол Улсын Төв банк (Монголбанк) хоёрдугаарт: арилжааны банкууд бөгөөд банк бус санхүүгийн байгууллагууд төлбөр тооцооны системд бодлогын болон техникийн талаасаа холбогдоогүй учир банкуудаар дамжуулан төлбөр тооцоогоо гүйцэтгэдэг. Монгол Улсын банкны системийн үйл ажиллагааны хууль эрх зүйн гол баримт бичиг нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, актууд юм.

1.1.1. Төв банк (Монголбанк)

1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан “Төв банкны тухай” хуулиар (*тус хуулинд 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон*) Төв банк (Монголбанк)-ны бүрэн эрх, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн мөнгөний бодлогыг Төв Банк (Монголбанк)-наас хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монголбанкны үйл ажиллагааны чиглэл хэсэгт “банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах” үйл ажиллагааг эрхлэхээр тусгагдсан.

1.1.2. Хувийн сектор

Банкууд

“Банкны тухай хууль” 1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан бөгөөд 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр уг хуулинд нэмэлт өөрчлөлт орсон. 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Монгол улсад 14 арилжааны банк /*үүнээс: төрийн өмчийн 1 банк, хувийн өмчийн 13 банк*/ үйл ажиллагаагаа явуулж байна.

1995 оны 10 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай” хуулиар иргэн, хуулийн этгээдээс хоорондын тооцоогоо банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар шийдвэрлэсэн.

“Банкны тухай” хуулийн 2 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлд заасны дагуу “гадаад валют, түүгээр илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэгслийг худалдан авах, худалдахтай холбогдсон банкны үйл ажиллагааг хуулиар² зохицуулна” гэж заасан байдаг.

Банк бус санхүүгийн байгууллага

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулиар банкны бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон. Уг хуулийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 7.1.6, 7.1.7 –д зааснаар “банк

² 1994 оны 5 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан “Валютын зохицуулалтын тухай хууль”

бус санхүүгийн байгууллага нь төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа” зэрэг үйл ажиллагааг эрхэлж болох ба энэ үйл ажиллагаатай холбогдсон төлбөр тооцоог банкны байгууллагаар зуучлуулж банк хоорондын төлбөр тооцоонд шууд бус оролцогчийн үүрэг гүйцэтгэхээр тусгагдсан.

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль” -аар банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулж байна.

Хадгаламж зээлийн хоршоо

Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр баталсан “Хоршооны тухай” хуулийн нэмэлт өөрчлөлт орсон хэсгээр зохицуулдаг. Уг хуулинд 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр “Хоршооны хадгаламж зээлийн тухай” гэсэн бүлгийг шинээр нэмж, 48-1-3 дахь заалтад “Хоршоо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ” гэж тусгасан байна.³

Төлбөрийн хэрэгсэлтэй холбоотой хууль эрх зүй

Чек, вексел

Чекээр төлбөр, тооцоо хийх үйл ажиллагааг хуульчилсан эрх зүйн акт хараахан гараагүй байна. Харин “Векселийн тухай хууль” нь 1995 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан. Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээд болон тэдгээрийн хооронд хийх төлбөр тооцоонд векселийг хэрэглэхтэй холбогдон үүсэх харилцааг чиглэгдэж байна.

Төлбөрийн карт

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 440 тоот тушаалаар “Төлбөрийн картын журам”-ыг баталсан. Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу төлбөрийн карттай холбоотой үйл ажиллагааны зарчмуудыг тогтоох, картын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, төлбөрийн картын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

Картаар банк хооронд төлбөр тооцоо хийх, Монголбанкнаас картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгоход Иргэний хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Төлбөрийн картын журам, Монголбанкнаас гаргасан бусад журмыг удирдлага болгоно.

1.1.3. Банк сүлжээ ба ТТТ

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан “Санхүүгийн чадавхийг хөгжүүлэх төсөл”-ийн дагуу төлбөр тооцооны системийг шинэчлэх ажлын хүрээнд “Төлбөр тооцооны төв”-ийг байгуулан ажиллаж байна.

³ Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

Уг төслийн хүрээнд Монголбанк нь Банк хоорондын их дүнтэй гүйлгээний бодит цагийн горим буюу “Банксүлжээ” системийг 2009 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс нэвтрүүлсэн юм. Энэ нь их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог боловсруулах хугацааг багасгах, боловсруулалтын бүх шатанд төлбөрийн мэдээллийн бүрэн бүтэн ба аюулгүй байдлыг хангах, харилцах дансны үлдэгдлийн мэдээллийг бодит цагаар хүлээн авах боломжийг оролцогчдод олгосноороо давуу талтай.

“Банк сүлжээ” болон Төлбөр тооцооны төвийн “Санхүүгийн дундын сүлжээ”-ны үйл ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 304 дүгээр тушаалаар баталсан “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 91 дүгээр тушаалаар баталсан “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”-аар зохицуулж байна.

1.2. Төв банк (Монголбанк)-ны үүрэг, хариуцлага

Монгол орны эдийн засгийн тусгаар тогтнолыг хангах үүднээс 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Орос, Монгол Улсын хамтарсан “Худалдаа аж үйлдвэрийн банк” нэртэйгээр тусгаар тогтносон БНМАУ-ын анхны банк байгуулагдсанаар банкны систем үүсч хөгжсөн. 1991 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр батлагдсан “Төв банк (Монголбанк)-ны тухай” хуулиар Монгол Улсын Төв банк буюу “Монголбанк” байгуулагдсан.

Монголбанкны Төв аппарат Улаанбаатар хотод байрлах бөгөөд хөдөө орон нутагт 17 салбар, Умард Ирланд, Их Британий нэгдсэн Вант улсын Лондон хотод Төлөөлөгчийн газраа ажиллуулж байна.

Монголбанк нь дараахь үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд: мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, мөнгөний бодлого боловсруулж хэрэгжүүлэх, Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх, банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах, гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж удирдах.

Монголбанкны газрын захирлуудыг багтаасан Захирлуудын Зөвлөл ажиллаж, гол шийдвэрээ энэ зөвлөлийн хурлаар хэлэлцэж, баталдаг.

Монголбанк нь төлбөрийн системийн операторын болон банк хооронд дамжуулах цахим мэдээний боловсруулагчийн үүрэг гүйцэтгэх ба банк хоорондын валютын арилжааны төлбөр тооцоог эрхлэх, төлбөр тооцооны системийг хөгжүүлэх, төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах, найдвартай, тасралтгүй байдлыг хангах бодлого боловсруулан, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

Монголбанк нь “Төв банкны тухай” хуулийн гуравдугаар бүлгийн 20 дугаар зүйлд заасан банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах үйл ажилагаатай холбогдуулан дараахь үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Банк хоорондын төлбөр, харилцан суутгах тооцоог зохион байгуулж, банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкин дахь тухайн банкны харилцах дансаар дамжуулан гүйцэтгэх,
2. Банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх өөрийн салбар байгуулан ажиллуулах,
3. Банк хоорондын төлбөр тооцооны журмыг тогтоох.

1.2.1. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах

Монголбанк нь Монгол улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрхийг эдэлдэг. Төв банкны хуулиар мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх, гүйлгээнд гаргахыг хориглоно. Монгол улсын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж төгрөг юм. Мөнгөн тэмдэгт нь цаасан дэвсгэрт болон зоосон хэлбэртэй байна. Монгол улсын мөнгөн тэмдэгтийн хэв, загварыг Улсын их хурал батална. Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төгрөг нь өөрийн нэрлэсэн дүнгээрээ Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдэж буй бүх төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн хууль ёсны хэрэгсэл юм. Төгрөгийг орлох төлбөрийн бусад хэрэгслийг Монголбанкны зөвшөөрлөөр төлбөр тооцоонд хэрэглэж болно.

Монголбанк нь өөрийн 17 салбараараа дамжуулан Монгол улсад мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргаж, мөн буцаан татан авдаг. Салбар бүр бэлтгэл сантай бөгөөд хөдөө орон нутаг дахь банкуудын салбарыг бэлэн мөнгөөр хангах гол зорилготой. Зөвхөн Төв Монголбанкинд гадаад гүйлгээний үйл ажиллагааг эрхлэн явуулдаг бөгөөд салбаруудад тус үйл ажиллагаа хийгдэхгүй.

1.2.2. Арилжааны банкууд руу хандсан төлбөр, тооцооны үйлчилгээ

Монголбанкны төв болон 17 салбарт арилжааны банкуудын зузаатгалыг чекээр дамжуулан гүйцэтгэж, холбогдох дансдын гүйлгээг хийдэг.

Монголбанкны төлбөр тооцооны үйлчилгээ нь банкуудаар дамжуулан мөнгөн дэвсгэрт болон зоосон тэмдэгтүүд гүйлгээнд гаргах, үнэт цаас болон бусад төлбөрийн цахим гуйвуулга хийх зэрэг үйл ажиллагаа юм. Хувь хүн, албан байгууллагуудын хувьд Монголбанкны төлбөр тооцооны үйлчилгээнд шууд орох нь боломжгүй бөгөөд эдгээр байгууллагууд нь эхлээд арилжааны банкуудын үйлчилгээг ашиглах боломжтой.

Монголбанк нь ТТТ-өөр дамжуулан гүйлгээ хийх, төлбөр тооцооны үйлчилгээтэй холбоотой гарсан хүү, шимтгэлийг төлөх үүрэгтэй ажиллаж байна. Тухайлбал: ТТТ-ийн 2007-2009 онуудын үйл ажиллагааны тайланг авч үзвэл 2007 онд нийт 18 сая, 2008 онд 88 сая, 2009 онд нийт 81 сая төгрөгийн алдагдалтай ажилласаныг Монголбанкны зүгээс төлсөн бөгөөд цаашид орлогоороо зарлагаа нөхөх төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлж байх зарчмыг баримталж байна.

1.2.3. Хяналт шалгалт, журам заавар

Монголбанк нь арилжааны банкуудын хувьд гол журам тогтоогч, хянан шалгагч нь юм. Монголбанкнаас арилжааны банкуудын үйл ажиллагаатай холбоотой дараахь журам, зааврыг боловсруулж, мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам,
- Банкинд онцгой дэглэм тогтоох тухай журам,
- Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам,
- Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам,

- Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам,
- Бусад холбогдох журам, заавар.⁴

Санхүүгийн зохиоцуулах хорооны зүгээс Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ууд, даатгалын байгууллагууд, Хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны брокерын компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж үйл ажиллагаанд нь холбогдох журам, заавар⁵-ын дагуу газар дээрх шалгалт болон зайнаас хяналт тавьж ажиллаж байна.

1.2.4. Мөнгөний бодлого

Монголбанк нь мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монголбанкны зүгээс “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөл”-ийг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн барьдаг.

Монголбанкнаас өргөн барьсан үндсэн чиглэлийн төслийг УИХ хэлэлцэж, Төв банкнаас дараагийн жилд баримтлах мөнгө, ханшийн бодлого, банкны салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээг тогтоол гарган баталдаг.

УИХ-аас батлагдсан мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн биеэлэлтийг Монголбанк УИХ-д улирал бүр тайлагнадаг байна.

1.3. Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн байгууллагууд

Монгол улсад төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн зуучлагч болох гол 3 байгууллага байдаг. Эдгээр нь арилжааны банкууд, Сангийн Яамны төрийн сангийн газар, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв юм. Эдгээр санхүүгийн байгууллага нь ямар үйлчилгээ үзүүлж байгаа, ямар заавар журмын субъект болж байгаагаараа хоорондоо ялгаатай. Монгол улс санхүүгийн зуучлагч болох банкны системд гол анхаарлаа хандуулж байдаг.

Үнэт цаасны зах зээлийн хувьд төлбөр тооцоо үзүүлэгч гол байгууллага нь төрийн эзэмшлийн “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” юм.

1.3.1. Арилжааны банкууд

Арилжааны банкуудын гол үйл ажиллагаа нь харилцах, хадгаламж төвлөрүүлэх, зээл болон төлбөр тооцооны үйлчилгээ хамарсан бусад банкны үйлчилгээг ард нийтэд үзүүлэх юм.

Арилжааны банкуудын үйл ажиллагаанд Монголбанкны зүгээс газар дээрх хяналт шалгалт болон сар бүр зайнаас хяналт тавьж ажилладаг. Банкуудад жилд хамгийн багадаа 1 удаа шалгалт хийдэг. Зарим тохиолдолд Монголбанкны СМА, МБСГ, Хуулийн хэлтэс болон Монгол улсын холбогдох Яамд, Засгийн газрын хэрэгжүүлэгч бусад агентлагуудтай хамтран газар дээрх шалгалт хийдэг.

⁴ Бусад холбогдох заавар, журмыг <http://www.mongolbank.mn/web/guest/184> вэв хуудаснаас үзнэ үү.

⁵ Эх үүсвэрийг <http://www.frc.mn> вэбхуудаснаас үзнэ үү.

Арилжааны банкуудад байршиж байгаа иргэдийн хадгаламжид Монгол улсын Их хурлаас 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулиар баталгаа гаргасан. Мөн хуулинд 2009 оны 3 дугаар сарын 6-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, 2.4 дэх заалтад иргэн хуулийн этгээдийн харилцах дансны үлдэгдэлд мөн баталгаа гаргасан байна. Хадгаламж болон харилцахын үлдэгдэлд баталгаа өгөх хугацаа нь дээрх хууль хэрэгжиж эхэлсэн өдөр буюу 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс хойш 4 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байхаар тусгасан байна.

Монгол Улсад арилжааны банкууд нь төлбөрийн системийн үндсэн буюу шууд оролцогч бөгөөд банкаар дамжин хийгдэж буй харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоог гүйцэтгэгч байгууллага юм.

Монголбанкнаас холбогдох журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан банк нь Банкны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 11 дүгээр зүйлд заасны дагуу дараахь төлбөр тооцооны үйлчилгээг эрхлэн явуулдаг. Үүнд:

1. Банк өөрийн харилцагчид төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээг түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлэх,
2. Банк харилцагчийн даалгавраар түүний харилцах дансны үлдэгдэлд багтаан мөнгөн хөрөнгийг шилжүүлэх гүйлгээ хийх. (Шүүх болон банкны эрх хүлээн авагчийн шийдвэртэй, эсхүл үл маргалдах журмаар төлөх тухай харилцагчийн гарын үсэг бүхий гэрээ, төлбөрийн баримтыг үндэслэн гүйлгээ хийснийг харилцагчийн даалгавраар гүйлгээ хийсэнд тооцно.)
3. Төлбөр тооцооны үйлчилгээний хөлсийг банк өөрөө тогтоох,
4. Банк нь банк хоорондын гүйлгээгээ Монголбанкин дахь харилцах дансаараа дамжуулан хийх,
5. Банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг хуулиар зохицуулах.

Монгол Улсад 2009 оны эцсийн байдлаар 14 банкны 1052 салбар, нэгжүүд харилцагч иргэд, байгууллагуудад санхүүгийн олон төрлийн үйлчилгээг санал болгож, банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкин дахь харилцах дансаар, гадаад валютын төлбөр тооцоог тухайн орны банкин дахь харилцах дансаар тус тус дамжуулан гүйцэтгэж байна.

1.3.2. Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллага

Сангийн яамны Төрийн сангийн газар (ТСГ)

Төрийн сангийн газар нь Төсвийн хуулийн дагуу төсвийн хэрэгжилтийг хангаж, төлбөр тооцоо гүйцэтгэх, тайлагнах, төсвийн алдагдал, төсөл хөтөлбөрийг хамгийн бага зардлаар төлбөрийн чадвартай уялдуулан санхүүжүүлэх үйл ажиллагааг эрхэлнэ.

ТСГ-ын Төлбөр тооцооны хэлтэс нь улсын төсвийн хэрэгжилтийг хангах үндсэн үүргийнхээ хүрээнд улсын төсвийн орлого, зарлагын гүйлгээг хийж, бүртгэх, түүнд хяналт тавин ажилладаг. Үүнд:

1. Төсвийн байгууллагын анхан шатны баримтыг үндэслэн төлбөр тооцоог хөнгөн шуурхай гүйцэтгэх,
2. Цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэл хөтлөх,
3. Банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх.

1.3.3. Бусад холбогдох байгууллагууд

Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (ТТҮЗ)

Монгол Улсын төлбөр тооцооны системийн оролцогч талуудын ашиг сонирхлыг нэгтгэх, хамтын ажиллагааг дэмжих замаар үндэсний төлбөр тооцооны системийг хөгжүүлэх зорилготойгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2008 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хамтарсан тушаалаар ТТҮЗ-ийг байгуулсан. Зөвлөлийн гишүүдэд Монголбанк, банкууд, Монголын банкны холбоо (МБХ), Сангийн яамны Төрийн сангийн газар (ТСГ), Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТТТХТ), Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Мэдээллийн технологи, харилцаа холбооны газар багтдаг.

ТТҮЗ нь Монгол Улсын төлбөр тооцооны системийн бүрэлдэхүүн хэсгүүдийг цогцоор нь хөгжүүлэх, бэлэн бус төлбөр тооцооны дэвшилтэт арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, төлбөрийн системийн эрүүл орчин, жигд ажиллагааг хангахад чиглэсэн бодлогын болон стратегийн баримт бичиг, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмж гарган ажилладаг.

Монголын банкны холбоо (МБХ)

Монголын банкны холбоо нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй банк болон банк бус санхүүгийн байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, төрөөс хараат бус, бие даасан, ашгийн бус, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

МБХ нь гишүүдийн хууль ёсны, нийтлэг ашиг сонирхол, эрхийг телеелен хамгаалах, банк, санхүүгийн салбарын өмнө тулгарсан бодлогын шинж чанартай асуудалд гишүүдийн үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх, банк, санхүүгийн салбарын үр ашигтай, эрүүл хөгжилд дэмжлэг үзүүлэхийг зорьж ажилладаг.

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)

СЗХ нь төрийн байгууллага бөгөөд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах нэгдсэн бодлого боловсруулж, банк бус санхүүгийн, даатгалын, хоршооны хадгаламж зээлийн үйл ажиллагаа, үнэт цаасны зах зээл, хуульд заасан санхүүгийн бусад харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хянах чиг үүрэгтэй.

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)

ББСБ нь СЗХ-ноос зөвшөөрөл авсны дагуу ББСБ-ын тухай хуулинд заасан үйл ажиллагааг эрхэлж байна.

2009 оны эцсийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу СЗХ-ноос зөвшөөрөл авсан нийт 172 банк бус санхүүгийн байгууллага ажиллаж байна.

Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТТТХТ)

1991 онд “Монголын Хөрөнгийн бирж” байгуулагдахад Төлбөр тооцоо, хадгаламжийн алба нэртэй зохион байгуулагдаж өмч хувьчлалын анхны бүртгэлийг хийж эхэлсэн. Засгийн газрын 2003 оны 72 тоот тогтоолоор Монголын хөрөнгийн биржийн бүтцээс тусгаарлагдан 100 хувь төрийн өмчит, бие даасан хуулийн этгээд болон ҮЦТТТХТ нэртэйгээр Монгол улсын хэмжээнд биржийн болон биржийн дүнд үүссэн үнэт цаасны төлбөр тооцоо, Санхүүгийн зохицуулах хорооноос авсан тусгай зөвшөөрлийн дагуу үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

2. Санхүүгийн бус байгууллагуудын ашигладаг төлбөрийн хэрэгслүүд

2.1. Бэлэн мөнгө

Бэлэн мөнгөөр төлбөр хийх нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийгдэж буй жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний төлбөр тооцооны үндсэн хэлбэр юм. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн дийлэнх нь иргэдэд бэлнээр олгогддог боловч зарим томоохон байгууллагууд цалинг төлбөрийн картаар олгож байна.

Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж төгрөг нь 1925 оноос хойш ашиглагдаж байна.

Монголбанкнаас 1993 онд гаргасан 1, 5, 10, 20, 50, 100, 500, 1000, 5000, 10000 төгрөгийн, 2006 онд гаргасан 20 000 төгрөгийн мөнгөн дэвсгэртүүд гүйлгээнд ашиглагдаж байна. Гүйлгээнд хамгийн их хэрэглэгддэг нь 50, 100, 10000 төгрөгийн дэвсгэрт байна⁶. Түүнчлэн, 20, 50, 100, 200, 500 төгрөгийн зоосон тэмдэгтийг гүйлгээнд гаргасан.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2009 оны эцсийн байдлаар 371.8 тэрбум төгрөг байна.

2.2. Бэлэн бус төлбөр тооцооны арга, хэрэгсэл

Монгол улсад арилжааны банкуудын санал болгодог олон төрлийн төлбөр, тооцооны үйлчилгээнд бэлэн бус төлбөрийн шилжүүлэг ордог бөгөөд дийлэнх хэсэг нь кредит шилжүүлэг байдаг.

Кредит шилжүүлэг

Банк хоорондын бэлэн бус төлбөр тооцоогоор 2009 оны эцсийн байдлаар нийт 2.6 сая ширхэг гүйлгээгээр 7.9 их наяд төгрөгийн гүйлгээ дамжин хийгдсэн байна⁷.

Үйлчлүүлэгчид төлбөрийн даалгаврын цахим ба цаасан хэлбэрийг сонгоно. Банк хоорондын төлбөр тооцооны системд төлбөрийн даалгаврын цахим хэлбэрийг ашигладаг бөгөөд банкууд нь төлбөрийн даалгаврыг үүсгэж, кодчилон дамжуулж, хүлээн авч, компьютерийн системд хадгална.

Дебит шилжүүлэг

Монгол Улсын төлбөр тооцооны системд банк хооронд дебит шилжүүлэг бага хэмжээгээр хийгддэг бөгөөд банк дотроо буюу тухайн харилцагч болон төлбөр хүлээн авагч байгууллагын данс нэг банкинд байршиж байх тохиолдолд тэдгээртэй хийсэн гэрээний үндсэн дээр орон сууцны төлбөр, суурин утас, гар утас, интернетийн төлбөр зэргийг дебит шилжүүлгээр хийдэг.

⁶ МБСГ-ын эдийн засагчийн тайлбараас.

⁷ Эх үүсвэр: ТБЗА-ны системийн зохицуулагчийн хийсэн “Банк хоорондын бэлэн бус төлбөр тооцооны судалгаа”, Хуудас № 3, Хүснэгт № 3

Картын төлбөр

1999 оны 2 дугаар улиралд томоохон арилжааны банкуудын нэг болох Голомт банк “Master card international” компанийн гишүүн болж Мастер картыг гаргаснаар олон улсын сүлжээнд холбогдсон бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картын үйлчилгээ Монголд анх нэвтэрсэн. Одоогийн байдлаар 12 банк энэхүү үйлчилгээг үзүүлж, эдгээрээс ХААН, Худалдаа хөгжил, Голомт зэрэг 3 банк өөрийн гэсэн картын төлбөрийн сүлжээтэй ба үлдсэн нь эдгээр банкуудын дэд гишүүн байдлаар төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Карт эзэмшигчдийн тоо жилээс жилд өсч 2005 оны эцэст 241 мянга байсан бол 2009 оны эцсийн байдлаар давхардсан тоогоор 1.9 саяд хүрч даруй 7 дахин өссөн үзүүлэлттэй байна. Эдгээрээс карт идэвхитэй ашиглагчид⁸-ын тоо 476.2 мянгад хүрсэн байна. Мөн үеийн байдлаар картын 20.2 сая ширхэг 1.4 их наяд тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна⁹. Монгол улсад чип болон соронзон тууз бүхий картууд төлбөр тооцоонд ашиглагдаж байна.

Дебит, Кредит карт

Голомт, Худалдаа хөгжил, ХААН банкууд дотоод, гадаадад ашиглагдах дебит, кредит картыг (Visa, Master, China UnionPay) гаргасан ба VISA, Master, China UnionPay, American Express, JCB банкны картыг хүлээн авч байна.

2009 оны эцсийн байдлаар дебит картаар 739.8 тэрбум төгрөгийн 9.9 сая ширхэг гүйлгээ, кредит картаар 64.6 тэрбум төгрөгийн 0.7 сая ширхэг гүйлгээ хийжээ¹⁰.

Урьдчилсан төлбөрт карт (e- money)

Карт эзэмшигч нь тусгай зориулалтаар мөнгөн хөрөнгийг урьдчилан тусгаарласан дансанд байршуулан шууд хандах боломжтой карт нь урьдчилсан төлбөрт карт юм. Монгол улсад урьдчилсан төлбөрт карт бага хүрээнд хэрэглэгдэж, голчлон үйлчилгээний байгууллагуудад хэрэглэгдэх бэлгийн карт (gift card) хэлбэрээр байна. “E-money” үйлчилгээний нэг хэлбэр болох Mobile money-ийн сүлжээ “Most money” нэртэйгээр 2009 онд үүсэн бий болсон. Энэ үйлчилгээг “МОСТ ПСИ” компани Монголын зах зээлд анх нэвтрүүлсэн. Үйлчилгээний гол зорилгыг нь авч үзвэл хэрэглэгч, байгууллага, банк гурвыг цахим мөнгөний зах зээл дээр холбож санхүүгийн зах зээл дээр ашиглаж буй хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологиор үр ашигт харилцааг хамгийн өндөр байлгахад чиглэсэн байна. Энэ үйлчилгээний оператороор үүрэн телефоны компани болох Мобиком ажиллаж байна.

АТМ, Импринтер төхөөрөмж болон ПОС, ПОБ терминал

Монгол улсад анх 2001 онд АТМ-ын үйлчилгээ нэвтэрсэн бөгөөд 2009 оны эцсийн байдлаар нийт 5649 ширхэг АТМ болон Импринтер төхөөрөмж, ПОС болон ПОБ терминал хэрэглээнд ашиглагдаж байна¹¹.

АТМ төхөөрөмжийн тоо жилээс жилд өссөөр 2009 оны эцсийн байдлаар 292 ширхэг төхөөрөмж суурилагдан ашиглагдаж байна. Харин Импринтер төхөөрөмж¹²-ийн тоо 2009 оны

⁸ Карт идэвхтэй ашиглагчид нь сард 5-аас доошгүй удаа гүйлгээ хийдэг карт эзэмшигчид юм.

⁹ Эх үүсвэр: ТБЗА-ны системийн зохицуулагчийн хийсэн “Төлбөрийн картын хэрэглээний судалгаа” хуудас №8, Хүснэгт №6

¹⁰ Эх үүсвэр: ТБЗА-ны системийн зохицуулагчийн хийсэн “Төлбөрийн картын хэрэглээний судалгаа” хуудас №8, Хүснэгт №7

¹¹ Эх үүсвэр: http://www.mongolbank.mn/c/document_library/get_file?uuid=278d2d40

¹² Картны гүйлгээг баталгаажуулах механик төхөөрөмж

эцэст 417 ширхэг байгаа бөгөөд 2008 оноос хойш жилээс жилд тоо нь цөөрч (2008 онд 470 ширхэг байсан) байна¹³.

ПОС терминал 2009 оны жилийн эцсийн байдлаар 3754 ширхэг, ПОБ терминал 1186 ширхэг байна. Мөн хугацаанд ПОС терминалаар 100.3 тэрбум төгрөгийн 1.7 сая ширхэг гүйлгээ, ПОБ терминалаар 453.6 тэрбум төгрөгийн 3.2 сая ширхэг, АТМ төхөөрөмжөөр 874.6 тэрбум төгрөгийн 15.2 сая ширхэг гүйлгээ хийгдсэн байна¹⁴.

Картын үйлчилгээ үзүүлдэг банкууд өөрийн сүлжээндээ картаар үйлчлэгч байгууллага (КҮБ)-ыг элсүүлж хүрээгээ тэлсээр 2009 оны эцсийн байдлаар нийт КҮБ-ын тоо 4078 хүрээд байна¹⁵.

2.2.1. Төлбөрийн бусад хэрэгсэл

Төлбөр тооцооны үндэсний зөвлөлөөс 2009 онд баталсан “Монгол улсын төлбөр тооцооны системийг 2009-2014 онд хөгжүүлэх стратеги” баримт бичигт дурьдсан “Бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болон төлбөр тооцооны системийн шинэ хэлбэрийг хөгжүүлэх” стратеги нь хөдөө, орон нутгийн алслагдсан байршилд амьдарч байгаа, банкны үйлчилгээ авах боломжгүй иргэдэд банк, санхүүгийн үйлчилгээг газар зүйн байршил, орлогын түвшин, цаг хугацаанаас үл хамааран хамгийн тохиромжтой хэлбэрээр хүртээл болгох зорилготой юм.

Бэлэн мөнгөний гуйвуулга

Иргэд өөрийн оршин суугаа газраас дотооддоо бэлнээр төгрөгийн гуйвуулгыг 3 банкны сүлжээгээр дамжуулан хийж байна.

Гадаад руу бэлэн валют банкинд тушааж гуйвуулах үйлчилгээ манай улсад өргөнөөр ашиглагдаж байна. “Western Union”-ийн гуйвуулгын үйлчилгээ 2000 онд нэвтэрсэн бөгөөд арилжааны 4 банк, “Moneygram” гуйвуулгын үйлчилгээ 2001 оноос нэвтэрч тус сүлжээнд арилжааны 6 банк нэгдсэн байна.

Вексель

Манай улсад энгийн болон шилжих вексель ашиглагдаж байна. Нийт банкны системийн дүнгээр 2009 онд 6.7 тэрбум төгрөгийн 7 ширхэг вексель авч, 61.2 тэрбум төгрөгийн 13 ширхэг энгийн вексель, 7.9 тэрбум төгрөгийн 1 ширхэг арилжааны векселийн төлбөр тооцоо хийгдсэн байна.

Чек

Манай улсын банкууд олон улсын нэр хvнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан замын болон нэрийн чекийг (ихэвчлэн Bank’s and personal, AMEX, VISA, MASTER) худалдах, худалдан авч мөнгөжүүлэх үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд энэхүү үйлчилгээгээр ихэвчлэн гадаадын иргэд үйлчлүүлж байна. 2009 онд 8858 ширхэг гадаад чекийн 6.1 тэрбум төгрөгийг дотооддоо мөнгөжүүлсэн ба 684 ширхэг дотоодын чекээр 1.6 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний валютыг гадаадад мөнгөжүүлсэн байна.

¹³ Эх үүсвэр: http://www.mongolbank.mn/c/document_library/get_file?uuid=278d2d40

¹⁴ Эх үүсвэр: http://www.mongolbank.mn/c/document_library/get_file?uuid=278d2d40

¹⁵ Эх үүсвэр: http://www.mongolbank.mn/c/document_library/get_file?uuid=278d2d40

2.2.2. Хөдөлгөөнт банк

Мобайл болон мессэж банк

Энэхүү үйлчилгээ нь манай улсад шинэлэг, анхан шатандаа явж байна. Банкны үйлчилгээ авах боломжгүй алслагдсан хөдөө орон нутгийн иргэдэд банкны үйлчилгээг хүргэх зорилгоор банкууд уг шинэлэг үйлчилгээг нэвтрүүлж байна. Уг үйлчилгээ нь банкинд байгаа өөрийн нэрийн данс руу ямар нэгэн тоног төхөөрөмж (тухайлбал: гар утас, интернэт гэх мэт) ашиглан алсаас хандан гүйлгээ хийлгэх үйлчилгээ юм. Мобайл банкны үйлчилгээг зарим банкууд нэвтрүүлж эхэлсэн ба 2009 оны эцсийн байдлаар уг үйлчилгээ 41.4 мянган хэрэглэгчтэй болж, тэдгээр нь 351.2 мянган ширхэг буюу 570.5 сая төгрөгийн гүйлгээ хийжээ.

Мессэж банкны үйлчилгээ нь өөрийн данс байршиж байгаа банк руу гар утсаа ашиглан мессэж бичин, холбогдох гүйлгээг хийлгэх үйл ажиллагаа юм. Сүүлийн жилүүдэд манай улсад мессэж банкны үйлчилгээ өргөжиж нийт 9 банк, 1 банк бус санхүүгийн байгууллага тус үйлчилгээг харилцагчдад үзүүлж байна. Мессэж банкны үйлчилгээний хамгийн том сүлжээ буюу “AMAR” үйлчилгээг ХАС банкны зүгээс харилцагчдад үзүүлж байна. Аль ч үүрэн телефон операторын хэрэглэгч худалдан авсан бараа, үйлчилгээнийхээ төлбөрийг гар утсаа ашиглан төлөхөөс гадна дансандаа мөнгө хийх, данснаасаа бэлэн мөнгө авахдаа банкны салбарт ирэлгүйгээр, мөн банкны салбар нэгж хаасан хойно агентаар дамжуулан үйлчилгээ авах боломжтой.

Интернет банк

Энэ үйлчилгээ нь интернэтээр дамжуулан банкинд байгаа өөрийн нэрийн дансаар гүйлгээ хийх үйлчилгээ юм.

Интернет банк үйлчилгээг 2002 оноос банкууд нэвтрүүлж, одоогийн байдлаар 9 банк энэхүү үйлчилгээг үзүүлж байна. 2009 оны байдлаар интернет банкны хэрэглэгч 3566-д хүрч, 3.3 тэрбум төгрөгийн 134.1 мянган ширхэг гүйлгээг интернет банк үйлчилгээг ашиглан хийжээ.

3. Банк хоорондын арилжаа, төлбөр тооцооны систем

3.1. Ерөнхий танилцуулга

Монгол Улс нь банкны 2 шатлалт системд шилжсэн үеэс банк хоорондын төлбөр тооцоо нь холимог дүнтэйгээр Монголбанкаар дамжин хийгддэг байсан бол 2006 оноос эхлэн их, бага дүнтэй гүйлгээ гэж ангилагдан 2 тусдаа системээр дамжин хийгдэж байна. Их дүнтэй гүйлгээ нь “Банксүлжээ” системээр, бага дүнтэй гүйлгээ нь Монголбанкны Төлбөр тооцооны төв (ТТТ)-өөр дамжин нийт төлбөр тооцооны үр дүнгийн тооцоо нь “Банксүлжээ” системд хаагдаж байна. Банк хоорондын гүйлгээ нь Монголбанкны ТТТ-ийн ажиллуулж буй “Санхүүгийн дундын сүлжээ”-ээр дамждаг.

3.1.1. “Банксүлжээ” систем

Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны ”Банксүлжээ” систем нь түүний оролцогчдоос илгээсэн гүйлгээ бүрийг тухайн цаг мөчид хүлээн авагч банк руу дамжуулан, үр дүнг бодит цагаар тооцож, банкуудад төлбөр тооцооны эрсдлийг хянах, өөрийн активыг зохистой удирдах боломжийг олгох, төлбөрийн бүх төрлийн систем (үнэт цаас, валютын арилжаа, бага дүнтэй төлбөр тооцоо гэх мэт)-ийг холбох үндсэн системийн үүрэг гүйцэтгэснээр Монгол Улсын төлбөрийн системийг олон улсын жишигт хүргэх ач холбогдолтой бодит цагийн төлбөр тооцооны систем юм. Өөрөөр хэлбэл, төлбөр тооцооны бодит цагийн горим нь нэг банкнаас нөгөө банк руу бодит цагт нэг бүрчилсэн байдлаар төлбөр тооцоо хийх систем юм.

Бодит цагийн төлбөр тооцоо гэдэг нь мэдээг ямар нэгэн хүлээлтгүйгээр дамжуулах процесс юм. Нэг бүрчлэн төлбөр хийх гэдэг нь мэдээ тус бүрийг нэг, нэгээр нь дамжуулах үйл ажиллагаа юм. Энэ систем нь нэг үйлдлээр төлбөр хийгдэх бөгөөд эргэж буцалтгүй, эцсийн байх зарчмаар төлбөр дамжуулах онцлогтой.

Үйл ажиллагааны заавар, журам

“Банксүлжээ” систем нь үйл ажиллагаандаа “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”-ыг мөрдөн, системийн оролцогчидтой “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ” байгуулан ажилладаг.

Системд оролцогч

”Банксүлжээ” системд оролцогчид нь Монголбанк, 14 банкны төв, Сангийн яамны Төрийн сангийн газар болно. Монголбанкны “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”-д оролцогчдын харилцаа, системд нэвтрэх, оролцоход тавигдах болзол, нөхцлүүд болон энэ системд оролцох эрхийг хязгаарлах, түр хориглох, бүрмөсөн хориглоход хүргэж болох нөхцөлүүдийг тодорхойлон нийтэд ил тод мэдээлсэн.

Системийн үүрэг:

“Банксүлжээ” систем нь дараахь үүрэгтэй. Үүнд:

а/ дараах ажиллагаатай холбоотой цахим төлбөрийг боловсруулах:

- Монголбанкны мөнгөний бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаа, (зээл, хадгаламж, гадаад валютын арилжааны төлбөр тооцоо болон бусад гүйлгээ)
- Оролцогчийн болон Монголбанкны өөрийн их дүнтэй төлбөр, Засгийн газрын банк хоорондын төлбөр,
- Банкуудын заавал байлгах нөөцтэй холбоотой төлбөр.

б/ дараах мэдээллээр хангах зорилгоор цахим мэдэгдэл боловсруулах:

- Оролцогчийн харилцах дансны үлдэгдэл,
- Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний үр дүн.

“Банксүлжээ” системийн төлбөр тооцоо хийгдэх ажиллагаа

Монголбанкны банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны системээр дамжин хийгдэх гүйлгээнд банк хоорондын төгрөг, валютын төлбөр тооцоо, банкуудын заавал байлгах нөөцөө хангах зорилгоор хийгдэх банк хоорондын зээл, хадгаламж, репо, урвуу репо, овернайт санхүүжилт, бэлэн мөнгөний чек, үнэт цаас, аккредитивтай холбоотой гүйлгээнүүд болон бусад төлбөр тооцооны системийн үр дүнгийн тооцоо хамрагдана.

Төлөгч банкны харилцах дансны үлдэгдэл хүрэлцээтэй байх тохиолдолд цахим төлбөрийн үр дүнгийн тооцоо нь харилцагч банкны дансанд бодит цагаар тусгагдана. Хэрэв харилцах дансны үлдэгдэл хүрэлцэхгүй бол үр дүнгийн тооцоо хийгдэхгүй бөгөөд цахим төлбөр нь дараалалд орно. Банкууд нь боловсруулагдсан төлбөрүүдийн хувьд эрэмбийг тогтоон дарааллыг зохицуулах боломжтой. Дараалалд орсон төлбөрүүд нь эрэмбээр хийгдэх бөгөөд адил эрэмбэтэй төлбөрүүдийн хувьд эхэлж ирснийг эхэлж гүйцэтгэх /FIFO/ зарчмыг баримтална. Монголбанкин дахь харилцах дансны үлдэгдлээс заавал байх нөөцийг тооцоход нөөц дутагдсан тохиолдолд Монголбанк нь банкинд дутууг нөхөх шаардлага тавьж Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хуульд заасан арга хэмжээг авах эрхтэй.

“Банксүлжээ” системийн ажиллах хуваарь

“Банксүлжээ” систем нь тогтмол цагийн хуваариар буюу улс нийтээр амрах амралт, баяр ёслолын өдрүүдийг оролцуулахгүйгээр Даваа гарагаас Баасан гарагт 9:00 – 18:00 цагийн хооронд үйл ажиллагаагаа явуулна.

“Банксүлжээ” системийн төлбөр тооцооны эрсдлийн удирдлага

Үр дүнгийн тооцооны эрсдлээс хамгаалах, удирдах зорилгоор Монголбанк нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд:

- “Банксүлжээ” системийн төлбөр тооцоог харилцах дансны үлдэгдлийн хэмжээнд хийх,
- “Банксүлжээ” системийн оролцогч банкуудын харилцах дансны үлдэгдэл нь төлбөр тооцоо хийгдэх боломжгүй болсон тохиолдолд уг асуудлыг шийдэх механизмыг ашиглах,

- “Банксүлжээ” системд алдаа гарсан тохиолдолд нөөц серверийг ашиглан төлбөр тооцоог хийх,
- Онцгой байдлын төлөвлөгөөг мөрдөж ажиллах, шаардлагатай тохиолдолд нөөц төв рүү шилжих.

“Банксүлжээ” системийн төлбөр тооцооны үнийн бодлого:

“Банксүлжээ” системийн төлбөр тооцооны хувьд Монголбанк нь банкуудад харилцах данс нээхэд шимтгэл авдаггүй, харин “Банксүлжээ” системээр төлбөр тооцоо гүйцэтгэхэд “Монголбанкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн 1.2 дахь заалтын дагуу дебит гүйлгээ тус бүрээс 150 төгрөгийн шимтгэл авдаг.

Тус системээр хийгдэж байгаа гүйлгээ нь 2009 оны эцсийн байдлаар нийт банк хоорондын гүйлгээний дүнгийн 97.5 хувь, гүйлгээний тооны 15.9 хувийг эзэлж байна.

3.1.2. Төлбөр тооцооны төв (ТТТ)

Монголбанкны Төлбөр тооцооны төв нь Монголбанк, нийт 14 арилжааны банкны төв, Сангийн яамны Төрийн сангийн газартай үндсэн шугам болох шилэн кабель, нөөц шугам болох физик кабелиар тус тус холбогдсон “Санхүүгийн дундын нэгдсэн сүлжээ”-гээр банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог зохион байгуулах, удирдах програм, техник хангамжийн цогц бүтэцтэй, түүний нөөц төвүүдийг хариуцан ажилладаг.

ТТТ нь банк хоорондын төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай ажиллагаагаар хангах үндсэн төв болон нөөц төвүүдтэй. Эдгээр төвүүдийн толгой компьютерууд нь зайлшгүй тохиолдолд мэдээллээ харилцан шилжүүлж ажиллах техник, технологиор бүрэн хангагдсан.

2006-2010 оны хооронд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний нийт тооны дундаж өсөлт 21%-тай бөгөөд гүйлгээний тоо 2010 оны эхний хагас жилийн байдлаар 2.7 сая ширхэгт хүрээд байна. 2009 онд сард дунджаар 186 мянган гүйлгээ дамжиж байсан бол 2010 оны эхний хагас жилийн байдлаар сард дунджаар 230 мянган ширхэг болж өсөх хандлагатай байна.

“Санхүүгийн дундын сүлжээ”-гээр дамжуулан дараах үйлчилгээг банк, санхүүгийн байгууллагуудад үзүүлдэг. Үүнд:

- 1) Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ, үр дүнгийн тооцооны дамжуулалт,
- 2) Банксүлжээ системийн сүлжээний холболтууд,
- 3) Монголбанкны үнэт цаасны онлайн системийн мэдээллийн дамжуулалт,
- 4) Зээлийн мэдээллийн системийн мэдээллийн дамжуулалт, (банкны төвөөс Монголбанк хүртэл)

Үйл ажиллагааны заавар, журам

“Санхүүгийн дундын сүлжээ” нь үйл ажиллагаандаа “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”-ыг мөрдөн, системийн оролцогчидтой “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ” байгуулан ажилладаг.

Системд оролцогч

“Санхүүгийн дундын сүлжээ”-ний оролцогчид нь Монголбанк, 14 банкны төв, Сангийн яамны Төрийн сангийн газар болно.

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ нь “Санхүүгийн дундын сүлжээ”-гээр дамжин явагддаг бөгөөд олон улсын санхүүгийн мэдээний стандарт болох ISO8583 болон Монголбанкнаас тавьсан бусад шаардлагыг хангасан байдаг.

“Санхүүгийн дундын сүлжээ”-ээр төлбөр тооцоо хийгдэх ажиллагаа

Монголбанкны ТТТ нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 91 дүгээр тушаалаар баталсан “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”-ын дагуу дараахь үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Оролцогчдоос банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоонд орох төлбөрийн цахим мэдээллийг “Санхүүгийн дундын сүлжээ” ашиглан ажлын өдрийн 9:00-16:30 цагийн хооронд хүлээн авч дамжуулна,
- Цахим мэдээллийг хүлээн авагчид дамжуулснаар банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоо хийгдсэн гэж үзнэ,
- Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний үр дүнгийн тооцоог хийж, үр дүнгийн цахим мэдээллийг “Банксүлжээ” системд өдрийн эцэст дамжуулна.

“Санхүүгийн дундын сүлжээ” системийн ажиллах цагийн хуваарь

“Санхүүгийн дундын сүлжээ” нь тогтмол цагийн хуваариар буюу улс нийтээр амрах амралт, баяр ёслолын өдрүүдийг оролцуулахгүйгээр Даваа гарагаас Баасан гарагт 9:00 – 17:00 цагийн хооронд үйл ажиллагаагаа явуулдаг.

“Санхүүгийн дундын сүлжээ” системийн эрсдлийн удирдлага

Үр дүнгийн тооцооны эрсдэлээс хамгаалах, удирдах зорилгоор Монголбанк нь дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- “Санхүүгийн дундын сүлжээ”-нд гэнэтийн саатал болон компьютер, програм хангамжийн алдаа гарсан тохиолдолд нөөц сервер, програм хангамжийг ашиглан банк хоорондын төлбөр тооцоог хийх,
- Онцгой байдлын төлөвлөгөөг мөрдөж ажиллах,
- Шаардлагатай тохиолдолд нөөц төв рүү шилжих.

“Санхүүгийн дундын сүлжээ” төлбөр тооцооны үнийн бодлого:

Тус сүлжээгээр банк хоорондын бага дүнтэй гүйлгээ дамжуулахад “Монголбанкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн 1.2 дахь заалтын дагуу дебит гүйлгээ тус бүрээс 150 төгрөгийн шимтгэл авдаг.

Тус системээр хийгдэж байгаа гүйлгээ нь 2009 оны эцсийн байдлаар нийт банк хоорондын гүйлгээний дүнгийн 2.5 хувь, гүйлгээний тооны 84.1 хувийг эзэлж байна.

3.1.3. Картын сүлжээ

Монгол Улсын хэмжээнд бэлэн бус төлбөр тооцоо давамгайлсан нийгмийг бий болгох, ялангуяа төлбөрийн картын үйлчилгээг хөгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-нд 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдөр сүлжээний үндсэн гишүүд болох ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, дэд гишүүд болох Капитал банк, Улаанбаатар хотын банк нэгдэж албан ёсоор нээлтээ хийсэн. Улмаар 2010 оны 10 дугаар сарын 18-нд “Голомт” банк албан ёсоор уг сүлжээнд нэгдсэн.

Үйл ажиллагааны заавар журам:

“Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-нд оролцогчдын гол мөрдөж ажиллах журам нь “Төлбөрийн картын журам” бөгөөд ТТТ-тэй ХААН банк, Худалдаа хөгжил, Голомт банкууд “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан ажилладаг. Тус гэрээний хавсралтаар батлагдсан дараахь журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах ёстой. Үүнд:

- “Банк хоорондын төлбөрийн картын үр дүнгийн тооцоог дамжуулах, үр дүнгийн тооцоог боловсруулах заавар”,
- “АТМ төхөөрөмжид хураагдсан картыг түгээх заавар”,
- “Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээтэй холбоотой үүссэн аливаа гомдол маргаан шийдвэрлэх заавар”,
- “Банк хоорондын төлбөрийн картын сүлжээний тасралтгүй байнгын үйл ажиллагааг хангах, түүнтэй холбогдон гарсан аливаа саатал, гэмтлийг шийдвэрлэх заавар”.

Системд оролцогч:

“Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ” –ний оролцогчид нь Монголбанк, арилжааны 9 банк байна. Банк хоорондын картын гүйлгээ нь “Санхүүгийн дундын сүлжээ”-ээр дамжин олон улсын санхүүгийн мэдээний ISO8583 болон Монголбанкаас баталсан журам, зааврын шаардлагыг хангасан байх ёстой.

“Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-ээр хийгдэх төлбөр тооцооны ажиллагаа

“Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-нд оролцогчдын хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу уг сүлжээгээр хийгдэх төлбөр тооцоо нь дараах зарчмаар явагдаж байна. Үүнд:

- Оролцогч талууд төлбөрийн картын гүйлгээнүүдийг “Санхүүгийн дундын сүлжээ”-гээр бодит цагийн горимоор 24 цагийн горимд (24/7), зөвхөн төгрөгөөр илэрхийлж дамжуулж, боловсруулна,
- Карт гаргагч болон карт хүлээн авагч банкны өдрийн эцсийн үр дүнгийн тооцоолол нь Монголбанкн дахь тухайн банкны харилцах дансаар харилцан суутгах зарчмаар, төгрөгөөр гүйцэтгэгдэнэ.

Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-ний ажиллах цагийн хуваарь

“Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”нь 24 цагийн горимд (24/7) зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-ний эрсдлийн удирдлага

Сүлжээний тасралтгүй байдлыг хангахын тулд “Банк хоорондын төлбөрийн картын сүлжээний тасралтгүй байнгын үйл ажиллагааг хангах, түүнтэй холбогдон гарсан аливаа саатал, гэмтлийг шийдвэрлэх заавар”-ыг дагаж мөрддөг.

Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-ний үнийн бодлого

Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-нд оролцогчдын хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу гүйлгээний шимтгэлийг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

Карт хүлээн авагч банк нь карт эзэмшигчээс:

- 1) АТМ төхөөрөмж дээр хийгдсэн банк хоорондын төлбөрийн картын бэлэн мөнгө авах гүйлгээнээс 500 (таван зуун) төгрөг;
- 2) ПОБ терминал дээр хийгдсэн бэлэн мөнгө авах 800,000.0 (найман зуун мянган) төгрөг хүртэлх гүйлгээнээс 500 (таван зуун) төгрөг;
- 3) АТМ төхөөрөмж, ПОБ терминал дээр хийсэн үлдэгдэл шалгах гүйлгээний шимтгэл 100 (нэг зуун) төгрөг тус тус авах.

ТТТ-нь нэгдсэн сүлжээний үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2011 оны 11 дүгээр сар хүртэл хугацаанд карт гаргагч, хүлээн авагч банкуудаас банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний шимтгэл авахгүй байхаар гэрээнд тусгасан. Харин дээрх хугацаанаас эхлэн банкуудаас дараах шимтгэлийг авч эхлэх бөгөөд банкууд карт эзэмшигч болон Картаар үйлчлүүлэгч банк /КҮБ/-аас одоогийн авч буй шимтгэлд өөрчлөлт оруулахгүй байхаар тогтсон байна. Үүнд:

- 1) АТМ төхөөрөмж, ПОБ терминал дээр хийгдсэн үлдэгдэл шалгах гүйлгээ тус бүрээс тогтмол 5 (таван) төгрөгийн,
- 2) АТМ төхөөрөмж, ПОБ терминал дээр хийгдсэн бэлэн мөнгө авах гүйлгээ тус бүрээс тогтмол 20 (хорин) төгрөгийн шимтгэлийг карт хүлээн авагч банкнаас авах,
- 3) ПОС терминал дээр хийгдсэн 3000 (гурван мянган) төгрөгнөөс дээш дүнтэй гүйлгээ тус бүрээс тогтмол 20 (хорин) төгрөгийн,
- 4) 3000 (гурван мянган) төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ тус бүрээс тогтмол 1 (нэг) төгрөгийн шимтгэлийг авах бөгөөд карт гаргагч, хүлээн авагч банкуудаас хувааж авах.

3.1.4. Гадаад валютын хил дамнасан гуйвуулгын систем

Гадаад валютаар хийгдэх хил дамнасан гуйвуулга нь дотоод болон гадаадын эрх бүхий банкуудын харилцах дансаар дамжин хийгддэг. Монгол Улсад гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 14 банк авсан байна. Тэдгээр банкууд нь гадаад төлбөр тооцоондоо аккредитив, гуйвуулга, баталгаа, төлбөрийн нэхэмжлэл гэсэн хэрэгслүүдийг ашиглаж байна. Гадаад валютын хил дамнасан гуйвуулга нь Монголбанк ба бусад орны төв банк хоорондын үр дүнгийн тооцооны гэрээ, Монголбанкны журам, эрх бүхий банк ба харилцагч банкуудын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулагдана.

Гадаад валютын хил дамнасан гуйвуулгыг данс эзэмшигчийн төлбөрийн даалгаврын дагуу харилцах данснаас хасалт хийж гүйцэтгэнэ.

Банкууд төлбөрийн даалгаврыг СВИФТ сүлжээгээр дамжуулна. Манай улс 1997 онд СВИФТ сүлжээнд нэгдсэн бөгөөд арилжааны банкууд энэхүү сүлжээг ашиглан гадаад төлбөр тооцоогоо гүйцэтгэж байна. Монголбанк 2009 он гарсаар СВИФТ-ийн сүлжээгээр нийт 7923 төлбөрийн мессеж хүлээн авч, 1964 мессеж илгээсэн бол өдөрт дунджаар 10.0 сая ам.долларын гүйлгээ хийдэг байна.

4. Үнэт цаасны төлбөр тооцоо

4.1. Арилжаалагдаж буй үнэт цаасууд

Монгол улсад Засгийн газар, Монголбанк, банк, санхүүгийн байгууллага, компани аж ахуйн зүгээс үнэт цаас, хувьцаа гаргаж банк хоорондын зах болон Хөрөнгийн бирж дээр зарж, борлуулдаг. Арилжааны үнэт цаасны зах нь богино хугацааны санхүүжилтийн гол зах зээл юм. Энэ зах зээлд оролцогчид нь үнэт цаас гаргагчид, брокер, хадгаламжийн байгууллагууд, даатгалын компаниуд, хөрөнгө оруулалтын компаниуд, банк бус санхүүгийн байгууллагууд болон хувь хүмүүс юм.

Хөрөнгийн зах зээлд гол бүтээгдэхүүн нь хувьцаа, бонд болон үүсмэл үнэт цаас байдаг бөгөөд одоогийн байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр зөвхөн компьютерийн санах ойд хадгалагддаг буюу биет бус хэлбэрийн хувьцаа, Засгийн газрын болон компанийн бонд зэрэг үнэт цаасууд арилжаалагдаж байна.

4.1.1. Монгол улсын Засгийн газар, Төв банкны үнэт цаасны арилжаа

Засгийн газрын үнэт цаас

Монгол улсын Засгийн газрын үнэт цаасыг нээлттэй болон хаалттай хэлбэрээр гаргадаг. Нээлттэй хэлбэр нь бондыг богино буюу дунд хугацаатай гаргаж, банкны систем, иргэд аж ахуйн нэгжид худалдаалдаг. Тухайлбал: 2004-2007 онд Засгийн газрын бондыг нээлттэй зах зээлд идэвхтэй арилжаалж байсан. Засгийн газрын бондыг гаргах нь дараах сайн талуудыг бий болгоно гэж Сангийн Яамнаас тодорхойлсон байдаг. Үүнд:

- Засгийн газар богино хугацаанд дотоод зах зээлээс эх үүсвэр татах боломж нээгдэнэ,
- Үнэт цаасны зах зээл хөгжих тулгуур болно,
- Тогтвортой жишиг хүү тогтсоноор банк, санхүүгийн хөгжилд түлхэц болно,
- Хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх чухал хөшүүргэ болж, мөнгөний эргэлтийг нэмэгдүүлнэ,
- Засгийн газрын өр, гадаадын хөрөнгө оруулагчдын шууд хамаарал буурч, санхүүгийн хараат бус байдал сайжирна,
- Ерөнхий эдийн засгийг тогтворжуулан, өрсөлдөөн болон холбогдох санхүүгийн дэд бүтцийг давхар хөгжүүлж, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлнэ.

Монгол улсын Засгийн газраас 2004 онд 44.2 тэрбум төгрөгийн бондыг зах зээлд шинээр гаргаж байсан бол, 2009 онд 720.6 тэрбум төгрөгийн бонд гаргасан байна.¹⁶

Төв банкны үнэт цаас

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ) нь Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм. Хугацаа, хүү, арилжаалагдах хэлбэр, үүргээрээ харилцан адилгүй үнэт цаасыг Монголбанк банк хоорондын зах дээр арилжаалж байна.

1 долоо хоногийн хугацаатай ТБҮЦ

¹⁶ Эх үүсвэр: http://www.mongolbank.mn/c/document_library/get_file?uuid

Нэг долоо хоногийн хугацаатай ТБҮЦ нь банкуудын нөөцийг удирдахад чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл юм. Энэ төрлийн үнэт цаасны хүү нь Монголбанкны бодлогын хүү болох бөгөөд банк хоорондын мөнгөний зах дээр хөтөч хүүний үүргийг гүйцэтгэдэг. Анх тогтмол хүүтэй, борлогдох хэмжээ нь хязгаарлалтгүй байсан энэхүү үнэт цаасыг 2007 оны 7 дугаар сард анх нэвтрүүлж 7 хоног бүрийн Лхагва гаригт банк хоорондын зах дээр арилжаалах болсон нь банкуудын сонирхолыг ихэд татсан юм. Учир нь энэ төрлийн үнэт цаас нь банкуудад илүүдэл нөөцөө богино хугацаатай хүү өгдөг активт чөлөөтэй байршуулах боломж олгосон бөгөөд уг бүтээгдэхүүн нэвтэрснээр банкуудын нөөцийн удирдлагад мэдэгдэхүйц өөрчлөлт гарчээ.

ТБҮЦ-ны хүүг зах зээлийн зарчимд илүү нийцтэй болгох, төгрөг болон валютын захын өгөөжийн тэнцвэр тогтох боломжийг бүрдүүлэх зорилгоор 2010 оны 5 дугаар сараас эхлэн 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны арилжааг тодорхой интервалд хүүгээр өрсөлдөх хэлбэрээр зохион байгуулж эхлээд байна. Ингэхдээ банкуудын ирүүлэх хүүний саналын дээд, доод хязгаарыг бодлогын хүүнээс +/-2 нэгж хувь байхаар тогтоож бодлогын зорилтот хүү уг арилжааны голч хүү байх юм. Энэхүү голч хүү нь дунд хугацаанд банк хоорондын захыг хүүг үйл ажиллагааны зорилт болгон ажиллах суурь нөхцлийг бүрдүүлэх болно.

12 долоо хоногийн хугацаатай ТБҮЦ

Санхүүгийн зах зээлийн зөв зохистой өгөөжийн муруйг бий болгохын тулд муруйн эхний цэгийг Төв банк, харин дунд болон урт хугацааны хүүг зах зээл өөрөө тодорхойлох ёстой. Иймээс Монголбанк 7 хоногийн ТБҮЦ-ны хүүгээр дамжуулан зөвхөн богино хугацааны банк хоорондын захын хүүнд нөлөөлдөг бол 7 хоногоос дээш хугацаатай ТБҮЦ-ны хүү нь банк хоорондын зах дээр тогтдог. Ингэхдээ дунд болон урт хугацааны хүү нь ТБҮЦ-ны ирээдүйн арилжаа, эрсдлийн болон нөөцийн үнийн хүлээлт дээр үндэслэх ажээ. Борлуулах хэмжээг нь хязгаарлан хүүгээр өрсөлдүүлэх зарчмаар арилжаалагддаг 12 долоо хоногийн хугацаатай энэхүү үнэт цаасыг Монголбанк 2007 оны 8 дугаар сард нэвтрүүлснээр харьцангуй урт хугацаатай санхүүгийн хэрэгслийг мөнгөний зах дээр бий болгох утвар нөхцлийг бүрдүүлсэн юм. Монголбанк энэ төрлийн үнэт цаасыг 2 долоо хоногийн давтамжтайгаар банк хоорондын зах дээр тогтмол арилжаалж байгаа тул мөнгөний зах 2-оос 12 долоо хоногийн (14-84 хоног) хугацааны үлдэгдэлтэй эрсдэлгүй хэрэгслээр хангагдаж байгаа юм.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 311 тоот тушаалаар баталсан “Төв банкны үнэт цаасны арилжааны журам” -ын дагуу Төв банкны үнэт цаасыг банкуудад хямдруулан арилжаалах үйл ажиллагааг Монголбанкны МБСГ-аас эрхлэн явуулдаг. ТБҮЦ-ын арилжаа нь програмаар хийгддэг бөгөөд арилжааны банкуудаас ТБҮЦ-ны үнэ хаялцуулах арилжаанд оролцох санал шууд бүртгэгдэж, бүртгэлийн хугацаа болон хамгийн бага хүүний дүнгээс хамаарч үнэт цаасны хуваарилалт нь програмаар шууд хийгддэг.

Мөнгөний бодлогын хэлтсийн үнэт цаас хариуцсан ажилтан нь Төв банкны үнэт цаасны арилжааны мэдэгдлийн өгөгдлийг буюу арилжааны дугаар, огноо, цаг, төлөгдөх огноо, хямдруулан дуудах доод үнэ, гаргасан хэмжээ зэргийг программд оруулдаг байна. Мөн банкуудаас Онлайн ирүүлсэн саналыг шалгаад батлахад ТТБГ-ын зээл хариуцсан нягтлан бодогч МБСГ-аас ирүүлсэн гүйлгээний шийдвэрийг үндэслэн тухайн гүйлгээг баталгаажуулдаг байна.

4.1.2. Компанийн үнэт цаас, хувьцаа

Монгол улсад “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (ҮЦТТТХТ) одоогоор зөвхөн дотоодын үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

“ҮЦТТТХТ” нь 2009 оны эцсийн байдлаар 38 хувьцаат компанийн 610,6 сая төгрөгийн ногдол ашгийг 101.4 мянган харилцагчийн дансанд байршуулж, Монголын хөрөнгийн биржийн гишүүн 44 брокер, дилерийн компани, 60 хувьцаат компанитай гэрээ байгуулан хамтран ажилласан байна.

ҮЦТТТХТ– ийн үндсэн үйл ажиллагаа:

Энэ үйл ажиллагаа нь үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын арилжааны баталгаажсан хэлцлийг үндэслэн төлбөрийг тодорхойлох, төлбөр тооцоог хийх,
2. Брокер, дилер компани болон харилцагчаас ирүүлсэн анхан шатны баримтыг хүлээн авч, төвлөрсөн хадгаламж дахь харилцагчдын мөнгөн хөрөнгийн гүйлгээний төлбөр тооцоог хийх,
3. Төлбөр тооцоотой холбоотой шимтгэл, хураамжийг тооцох.

Төвлөрсөн хадгаламжийн дансаар 2009 оны эцсийн байдлаар нийт 1098 харилцагч 3308 удаа 24.2 тэрбум төгрөгийг төвлөрсөн хадгаламж дахь дансандаа байршуулсан бол 4192 харилцагч 7103 удаа төвлөрсөн данснаас 23.4 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээ, нийт 5290 харилцагч 10410 удаа 47.7 тэрбум төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийсэн байна.

2009 онд хийгдсэн орлого, зарлагын гүйлгээг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал орлогын гүйлгээ 71.8 хувь, зарлагын гүйлгээ 73 хувиар, харилцагчийн тоо 58.6 хувиар тус тус буурсан байгаа нь үнэт цаасны зах зээлд оролцогчдын идэвхи буурсныг харуулж байна.

2009 оны эцсийн байдлаар “ҮЦТТТХТ”-ийн төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй хувьцаа 2.3 тэрбум ширхэг, Засгийн газрын бонд 170.0 мянган ширхэг, 617.9 мянган ширхэг, төвлөрсөн хадгаламжинд данстай дотоодын 662 аж ахуйн нэгж, 443.3 мянган иргэн, гадаадын 69 аж ахуйн нэгж, 660 иргэн байна.

4.2. Арилжааны горим

4.2.1. Монгол улсын Засгийн газар, Монголбанкны үнэт цаас

Засгийн газрын үнэт цаас нь нээлттэй зах зээлд арилжаалагдсан бол “ҮЦТТТХТ” ХХК-аар дамжуулан төлбөр, тооцоог хийдэг.

Төв банкны үнэт цаасны арилжааг дараахь дарааллаар хийж, төлбөр тооцоог гүйцэтгэдэг. Үүнд:

- 1) ТБҮЦ-ыг гаргах тухай шийдвэрийг үндэслэн “ТБҮЦ-ны арилжааны мэдэгдэл”-ийг “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр банкуудад хүргүүлэх,

2) МБСГ нь ТБҮЦ-ны арилжааны мэдэгдлийг арилжаа хийх өдрийн 9:30 цагт багтаан “Банк хоорондын цахим арилжааны систем”-д оруулах,

3) Монголбанкнаас зарласан хүүгийн түвшинд үнэт цаас худалдан авах саналаа банкууд арилжаа явагдах өдрийн 9:30-11:00 цагийн хооронд “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулан МБСГ-т ирүүлдэг,

4) Банкуудаас ирүүлсэн саналыг үндэслэн үнэт цаасны програмаар ирүүлсэн банкуудын саналыг ирүүлсэн дарааллаар баталгаажуулах замаар ТБҮЦ-ны арилжааны хувиарлалтыг хийх,

5) МБСГ -нь 12:00 цагт ТТБГ-т “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр гүйлгээний шийдвэрийг дамжуулснаар гүйлгээ хийгддэг байна.

Монголбанкнаас 7 хоногийн хугацаатай үнэт цаасны хүүг зарлаж, хэмжээг хязгаарлахгүйгээр, харин 12 долоо хоногийн хугацаатай үнэт цаасыг хүүгээр өрсөлдүүлэх зарчмаар арилжаалж байна.

4.2.2. Компаний үнэт цаас, хувьцаа

“Монголын хөрөнгийн бирж”-ийн мэдээллийн баазаас 2007 онд “ҮЦТТГХТ” ХХК-ийн мэдээллийн баазыг бүрэн салгаж, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаанд олон улсын шаардлагад нийцүүлсэн мэдээллийн иж бүрэн “E clearing” системийг шинээр нэвтрүүлсэн. Уг систем нь үнэт цаасны төлбөр тооцооны дэд систем, хадгаламж, өмчлөх эрх бүртгэлийн дэд систем гэсэн 2 үндсэн бүрэлдэхүүнтэй.

Эдгээр дэд системүүд нь мэдээллийн сан дээр суурилсан програм хангамжийн нэгдсэн тогтолцоо бөгөөд мэдээлэл боловсруулах, харилцагчид дансны хуулгаа интернетээр авах боломжтой болсон төдийгүй цаашид интернет банкны үйлчилгээ ашиглаж үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэх боломж бүрдэж байна.

4.3. Төлбөр тооцоо

4.3.1. Монгол улсын Засгийн газар, Монголбанкны үнэт цаас

Монгол улсын Засгийн газар, Монголбанкны үнэт цаас нь зөвхөн цахим хэлбэрээр байдаг. Арилжааны банкууд нь Монголбанкинд харилцах данстай бөгөөд эдгээр дансаар дамжуулан үнэт цаасны холбогдох гүйлгээг хийдэг.

Монголбанкны “Банк сүлжээ” систем нь бодит цагийн горимд суурилсан, төлбөрийг шилжүүлсэн тохиолдолд үнэт цаасыг маш шуурхай, эцсийн байдлаар, тухайн цагт нь шилжүүлдэг болно.

4.3.2. Компаний үнэт цаас, хувьцаа

Ихэнх үнэт цаас, хувьцаа нь “ҮЦТТГХТ” ХХК дээр төвлөрсөн байдаг. Тус компани нь хөрөнгийн зах зээл дэх үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоог холбогдох талуудын өмнө 3

дагч этгээдийн хувиар гүйцэтгэж, арилжааны банкинд төлбөрийн баримтыг цаасан хэлбэрээр, хүргүүлж гүйцэтгэж байна. Энэ нь төлбөр, тооцооны болон төлбөрийн эрсдэлтэй байдлыг үүсгэж байгаа болно.

Цаашид Монголбанкны зүгээс “ҮЦТТХТ” ХХК-тай хамтран, хоорондоо цахим хэлбэрээр холбогдож, төлбөр, тооцоог “Банк сүлжээ” системээр гүйцэтгэх чиглэлийг баримтлан ажиллаж байна.

ТӨЛБӨРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Ашигласан материалууд:

- i. ТБЗА-наас өмнө бэлтгэж байсан “Улаан ном” –ны анхны танилцуулга,*
- ii. Сангийн Яам, Монголбанк, банк, санхүүгийн байгуулагуудын цахим хуудсууд,*
- iii. АНУ-ын төлбөрийн системийн танилцуулга, материал,*
- iv. ТТТ-ийн ажилтнуудын хийсэн семинарын танилцуулга, материал,*
- v. ТБЗА-наас хийсэн 2009, 2010 оны эхний хагас жилийг хамарсан судалгаанууд,*